

“ЧАДВАРЛАГ ОЮУТАН -2019” МОНГОЛЫН АНАГААХЫН ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО

2019 оны 4 сарын 27-ны өдөр Дорноговь аймаг дахь Анагаах ухааны сургуулийн оюутны эрдэм шинжилгээний хурал “Чадварлаг оюутан – 2019” нэрийн дор Монгол улсын хэмжээнд эмч эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэдэг бүх их дээд сургуулийн хүрээнд амжилттай зохион байгуулагдлаа. АШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь АУС-ийн захирал, АУ-ны доктор дэд профессор Ц.Цабшир хурлыг нээж үг хэлж, Дорноговь аймгийн засаг даргын орлогч Г.Эрдэнэцэцэг мэндчилгээ дэвшүүлж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэв.

Зочин илтгэгчээр МУ-ын гавьяат багш, АУ-ы академийн гишүүн, БУ-ы доктор, профессор И.Пүрэвдорж уригдан “Клоны арга ба үүдэл эс”, “Хувь хүний ёс зүйгээс зан чанарын ёс зүйд шилжихүй” сэдвээр лекц уншив.

“Чадварлаг оюутан – 2019” эрдэм шинжилгээний хуралд АШУҮИС-ийн бүрэлдэхүүн 7 сургууль, салбар 3 сургууль, хувийн хэвшлийн 5 сургуулийн судлаач оюутнууд, эрдэмтэн багш нар 69 бүтээл ирүүлснээс 2-р шатанд 16 илтгэл хэлэлцүүлээ. Үүнээс

- Тэргүүн байр: Г.Буянтүлхүүр /БАС-5/ нарын “Шалтгаан тодорхойгүй эпилепсийн үед хлорын ионы сувгийн генүүдэд мутаци тодорхойлсон дүн”
- Дэд байр: Т.Сувд /БАС-501/ нарын “Насжилт хамааралт шар толбоны сөнөрөл өвчтэй хүмүүст VEGF-A генийн RS833061 полиморфизмыг тодорхойлсон дүн”
- Гутгаар байр: З.Гэрэлцэцэг /БАС-501/ нарын “Цусны донорын захын цусанд НК ба НКТ эсийн дундаж тоог флоуцитометрээр тодорхойлсон дүн” илтгэлүүд тус тус шалгарав.

Анагаах эрдэмд шимтэн суралцахын зэрэгцээ судалгаа, шинжилгээний ажил хийж бүтээлээ хэлэлцүүлсэн оюутан залуус, удирдан чиглүүлсэн эрдэмтэн багш нартаа талархал илэрхийлж эрдэм, судалгааны ажилд нь амжилт хүсье.

